



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№134 /348/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.08.02

Тусгай дугаар

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭГДСЭН ЛАБОРАТОРИ БАЙГУУЛАГДСАНЫ 20 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ӨРГӨН ДЭВШҮҮЛЬЕ!

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм, генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагч, эх орноо батлан хамгаалах үйлсэд хөдөлмөр зүтгэл, залуу насаа зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмадууд Та бүхэнд Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори байгуулагдсаны түүхт 20 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Монголын Ардын Армийн болон орчин цагийн Зэвсэгт хүчний хөгжил дэвшлийн түүхэн цаг үед Цэргийн химийн лаборатори, Мал эмнэлэг бактери шинжилгээний лаборатори, Эрүүл зүйн бичил амь судлал-химийн лаборатори, Шатахууны лаборатори, Хэмжил зүйн лабораториуд нь тус тус үүсэн байгуулагдаж бие даан үйл ажиллагаа явуулж байгаад ЗХЕШ-ын даргын 2002 оны тушаалаар дээрх лабораториудыг нэгтгэн ЗХНЛ болгон зохион байгуулж, улмаар ЗХЖШ-ын даргын 2008 оны тушаалаар Мал эмнэлэг, бактери шинжилгээний лабораторийг ЗХНЛ-ийн бүтцэд оруулсан нь тус лабораторийн түүхийн үндэс нь болдог. ЗХНЛ нь Зэвсэгт хүчний анги, салбар, аж ахуйн нэгж байгууллагуудын хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулах, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт, шатахуун, тос тосолгооны материал, тусгай шингэн, хүнс, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн, химийн хортой болон тусгай цэвэрлэгээний бодис, урвалжийн чанар байдлыг тодорхойлох, мал, амьтанд мал эмнэлгийн үзлэг оношилгоо, сорилт шинжилгээний ажил үйлчилгээг үзүүлэх үндсэн үүргээ нэр төртэй биелүүлсээр ирсэн юм. Энэ хугацаанд Нэгдсэн лабораторийн үйл ажиллагаа нь "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага" MNS ISO/IEC стандартад нийцсэн тул 2003 онд итгэмжлэгдэж, 2005, 2008, 2010, 2014, 2018, 2021 онуудад Үндэсний Итгэмжлэлийн төвөөс "Итгэмжлэл"-ийн эрх аван ажиллаж байна. Тус лабораторид орчин цагийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, боловсон хүчний мэдлэг чадварыг тасралтгүй дээшлүүлэх зорилгоор "ЗХНЛ-ийг 2020-2030 онд хөгжүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулан, ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар дэмжигдэн,

Батлан хамгаалахын сайдын 2020 оны тушаалаар батлагдан амжилттай хэрэгжиж байна. Зэвсэгт хүчний хөгжил дэвшилд манай хамт олны оруулсан хувь нэмрийг ЗХЖШ-ын удирдлага өндрөөр үнэлж, Зэвсэгт хүчний 2021 оны "Тэргүүний салбар"-аар шалгаруулсаныг энд онцлоход таатай байна. Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд оюун ухаан, бие сэтгэл зүрх, хөдөлмөр бүтээлээрээ хүчин зүтгэж явсан ахмад буурлууд, өнөөдөр тэдний ариун үйлсийг нэр төртэй залгамжлан хөдөлмөрлөж буй хамт олон, тэдний ар гэрийнхэнд эрүүл энх, аз жаргал, ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Монгол цэргийн сүлд хийморь үеийн үед мандан бадрах болтугай.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ДАРГА ДЭД ХУРАНДАА У.ГАНЗАМ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭГДСЭН ЛАБОРАТОРИ 20 НАС ХҮРЛЭЭ



Өнөөдөр Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн 20 жилийн ой тохиож байна. Ойн хүндэтгэлийн арга хэмжээнд Зэвсэгт хүчний ХШҮГ-ын дарга хурандаа Ж.Өсөхбаяр, ЗХЖШ-ын МТГ-ын Хэмжилзүйн албаны дарга хурандаа Ч.Бат-Эрдэнэ, Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн дарга дэд хурандаа У.Ганзам болон үе үеийн ахмад ажилтан нийт бие бүрэлдэхүүн оролцлоо. Тусдаа үйл ажиллагаагаа явуулж байсан Хэмжил зүйн лаборатори, Шатахууны лаборатори, Химийн лаборатори, Эрүүл зүй, бичил амь судлал-Химийн лабораториудыг нэгтгэн, Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори болгон үйл ажиллагаа явуулж эхлээд ийнхүү 20 жил болж байгаа юм.



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН УДИРДЛАГЫН БҮЛЭГ

ЗХНЛ нь 2002 онд шинэ бүтэц, орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр Удирдлагын бүлэг буюу штабын бүрэлдэхүүнийг шинээр томилон ажиллаж эхэлсэн. Удирдлагын бүлгийн ерөнхий инженер, улсыншалгагчаар хурандаа Ч.Бат-Эрдэнэ, Ж.Одсүрэн, дэд хурандаа Б.Наранбадрал, М.Орхон, У.Ганзам, ахмад Т.Шинэбаатар, нууцын дарга, архивын эрхлэгчээр ахлах ахлагч Ш.Цэцэгноров, сургагч ахлагч Д.Дашмаа, ахлах ахлагч Ш.Содном, ерөнхий нягтлан бодогчоор Ж.Дуламжав, Б.Бат-Эрдэнэ, С.Туяа нар ажиллаж ирсэн. Удирдлагын бүлэг нь ЗХНЛ-ийг хөгжүүлэх, бодлого, удирдлагын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх, лабораториудад ажиллагсдын ажиллах таатай, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх,



боловсон хүчнийг мэдлэг боловсрол, ур чадвараа дээшлүүлэх, олон талаар хөгжин дэвшихэд бүх талын дэмжлэг үзүүлэн, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Мөн Монгол Улсын хууль, тогтоол, шийдвэр, БХЯ, ЗХЖШ-аас ирүүлсэн удирдлагын баримт бичгийг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Штабын бүрэлдэхүүнд данс хөтлөгч няраваар Ж.Нэргүй, С.Цэрэннадмид, Г.Алтанзаяа, Д.Очтуяа, оператор-бичээчээр Б.Гантуяа, үйлчлэгчээр Д.Бямба, Э.Анхтуяа, харуулаар Н.Амгаланбаатар, Э.Галбаяр, Х.Нямдорж, С.Батболд, Г.Дэчинравдан, Элбэг, Х.Гантулга, С.Дашбалжир, Н.Даваажав, Н.Ариунболд, Л.Эрдэнэ, Ш.Батмөнх, Б.Ариунбаатар, Б.Энхдаваа нар ажиллаж ирсэн.

АМЖИЛТ БҮТЭЭЛ

2002 оноос хойш Стандарт Хэмжил Зүйн газрын болон Итгэмжлэлийн үнэлгээний төвийн үнэлгээний байгууллагаар нийтдээ 8 удаагийн давтамжтай 2-4 жилийн хугацаагаар MNS ISO/IEC 17025-2007, 2018 стандартын дагуу итгэмжлэлийн эрх авч, улсын болон Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байна.



ТҮҮХЭН ТОВЧОО

ЗХЕШ-ын даргын 1999 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн тушаалаар БХИС-ийн Хэмжил зүй, Химийн лаборатори болон Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн Шатахууны лабораториудыг нэгтгэн Зэвсэгт хүчний Төв лаборатори болгон зохион байгуулж, анх удаа бие даасан байдлаар ажиллуулж эхэлсэн түүхтэй.

Улмаар ЗХЖШ-ын даргын 2002 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн тушаалаар Эрүүл зүйн бичил амь судлал-Химийн лабораторийг тус лабораторид нэгтгэж, Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори болгон тайван цагийн орон тоог шинэчлэн баталсан юм.

ЗХЖШ-ын даргын тушаалаар 2002 оны 05 сард ЗХНЛ-ийг Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн ХҮТР-ын цэргийн байрны нэгдүгээр давхарт шилжүүлэн байрлуулсан бөгөөд Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори бие даасан санхүүгийн үйл ажиллагаа явуулах эрх авч, 2005 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн санд орлогын данс нээлгэн, эхлэлтийн балансыг хийж эхлүүлсэн юм.

ЗХЖШ-ын даргын 2008 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн тушаалаар Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн Мал эмнэлгийн бактери шинжилгээний лабораторийг тус лабораторид нэгтгэн тайван цагийн орон тоог шинэчлэн баталж мөрдүүлсэн.

Үүнээс өмнө байгуулагдсан доорх лабораториуд нь тус тусдаа байрлаж, үйл ажиллагаагаа явуулж байв. Үүнд:

•1962 онд Ардын цэргийн Ерөнхий штабын Химийн албаны захиргаанд Химийн лаборатори

•1972 онд "Хүн, мал эмнэлгийн нэгдсэн лаборатори"

•1973 онд "Ардын

Армийн ариун цэвэр, халдвар судлалын групп" нэртэйгээр Эрүүл зүйн бичил амь судлал-Химийн лаборатори

•1982 онд Ардын Армийн 109 дүгээр төв лаборатори нэртэйгээр Шатахууны лаборатори

•1983 онд Ардын Армийн Хэмжилзүйн 137 дугаар төв лаборатори нэртэйгээр Хэмжил зүйн лаборатори тус тус үйл ажиллагаагаа явуулж байв.

"Зэвсэгт хүчний Төв лабораторийн дүрэм" нь ЗХЕШ-ын даргын 1999 оны 10 дугаар 26-ны өдрийн 765 дугаар тушаалаар анх батлагдаж, 2002 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс лабораториуд нэгдэж үйл ажиллагаа явуулж эхэлснээр, "Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн дүрэм" нь ЗХЖШ-ын даргын 2002 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 899 дүгээр тушаалаар анх батлагдаж байсан бөгөөд ЗХЖШ-ын даргын 2006 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 78 дугаар тушаал, 2010 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 341 дүгээр тушаалуудаар тус тус шинэчлэн батлагдаж байсан.

ЗХЖШ-ын даргын 2009 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 1176 дугаар тушаалаар одоогийн байрыг Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн харьяа 308 дугаар салбараас хүлээн авч, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн барилгын засварын бүлгээр сэргээн засварлан, тохижилтын ажлыг хийлгэн, шилжин байрлаж, үйл ажиллагаагаа явуулж байна. Нэгдсэн лаборатори нь "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага" MNS ISO/IEC стандартад нийцсэн тул 2003 онд итгэмжлэгдэж, 2005, 2008, 2010, 2014, 2018, 2021 онуудад Үндэсний Итгэмжлэлийн төвөөс үйл ажиллагаа явуулах "Итгэмжлэл"-ийн эрх аван ажиллаж байна.

ХЭМЖИЛ ЗҮЙН ЛАБОРАТОРИЙН ТОВЧ ТҮҮХ



Хэмжилзүйн лаборатори нь МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1983 оны 30 дугаар тогтоолыг үндэслэн Батлан хамгаалах яамны сайдын 1983 оны 27 дугаар тушаалаар "Ардын Армийн Хэмжилзүйн 137 дугаар төв лаборатори" нэртэйгээр байгуулагдаж ирсэн түүхтэй. Хэмжилзүйн лаборатори нь "Хэмжил зүйн тухай", "Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай" Монгол Улсын хуулийг хэрэгжүүлж, "Цэргийн хэмжил зүйн журам", "Зэвсэгт хүчний хэмжил зүйн хангалтын заавар"-ын дагуу Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт ашиглагдаж байгаа зэвсэглэл, радио техникийн цахилгаан, механик, даралт, эзлэхүүн багтаамж, шугам өнцгийн хэмжих хэрэгслийг шалгаж тохируулах, баталгаажуулах, объект, байгууламжийн аянга зайлуулагч, тоног төхөөрөмжийн газардуулгуудад хэмжилт хийх үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн. Түүнчлэн Зэвсэгт хүчний

нэгтгэл, анги, байгууллагуудын зэвсэглэл, цэргийн техникийн хэмжих хэрэгсэлд радио, цахилгаан, механик, даралт, эзлэхүүн багтаамж, шугам өнцгийн хэмжлийн төрлөөр засвар, шалгалт тохируулга, баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэж ирсэн.

Тус ажлыг дэд хурандаа Л.Галбадрах, дэд хурандаа Ж.Энэбиш, хошууч Д.Явуухүү, Б.Жамъянгарав, ахлах ахлагч Б.Цогтсайхан, хошууч Р.Хуяг, О.Эрдэнэдалай нар гүйцэтгэж байв.

ЗХЕШ-ын даргын 2002 оны тушаалаар Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори болгон бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, Хэмжил зүйн лаборатори нь Радио, цахилгаан дулааны хэмжих хэрэгслийг тохируулах, баталгаажуулах, засварлах тасаг, Механик, даралтын хэмжих хэрэгслийг тохируулах, баталгаажуулах, засварлах тасаг, Эзлэхүүн багтаамж, шугам өнцгийн хэмжих хэрэгслийг тохируулах, баталгаажуулах, засварлах тасаг болон зохион байгуулагдсан.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ҮЕ ҮЕИЙН ДАРГА НАР



Дэд хурандаа П.Очиржав 1999-2000 он



Хурандаа Ж.Жаргалсайхан 2000-2003 он



Хурандаа Ч.Бат-Эрдэнэ 2003-2005, 2012-2016 он



Дэд хурандаа Ц.Хосбаяр 2005-2006 он



Дэд хурандаа Д.Чулуунбаатар 2006-2010 он



Дэд хурандаа Б.Наранбадрал 2010-2012 он



Хурандаа Г.Баярсайхан 2016-2018 он



Дэд хурандаа У.Ганзам 2018 оноос

ЭЗБАС-ХИМИЙН ЛАБОРАТОРИЙН ТОВЧ ТҮҮХ



Эрүүл зүйн бичил амь судлал-Химийн лаборатори нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолыг үндэслэн Батлан хамгаалах яамны сайдын 1973 оны 197 дугаар тушаалаар "Ардын Армийн ариун цэвэр, халдвар судлалын групп" нэртэйгээр анх байгуулагджээ.

Э С Б А С - Х и м и й н лаборатори нь Зэвсэгт хүчний анги, байгууллагад

хэрэглэгдэж, нийлүүлэгдэж байгаа хүнс, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн, ус, хөрс, агаар, арчдас, ариун материалд хими, нян судлалын шинжилгээ хийж, чанар, аюулгүй байдлыг тодорхойлох, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, халдварын голомтыг ариутгах, хортон мэрэгч, шавжийг устгах үндсэн үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн. Түүнчлэн хүнс, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн, ус, хөрс, агаар, арчдас, ариун материалд хими, нян судлалын шинжилгээ хийж, чанар, аюулгүй байдлыг тодорхойлох үндсэн үүргээ сайн биелүүлж ирсэн.

Нян судлагч их эмчээр хошууч П.Цэнд, ахмад Р.Цэцэгмаа, А.Энхбат, С.Нэргүй, химичээр Ц.Дулмаа, Б.Оюунбилэг, Д.Оюунгэрэл, лаборантаар ахлах ахлагч Ш.Бор, Н.Данзанням, Ц.Оюунчимэг, Л.Цэцэгсайхан, П.Гантулга, М.Алтансүх, автоклавчээр Л.Жаргал, П.Чимэдцогзол нар ажиллаж байв.

ШАТАХУУНЫ ЛАБОРАТОРИЙН ТОВЧ ТҮҮХ

Шатахууны лаборатори нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг үндэслэн Батлан хамгаалах яамны сайдын 1982 оны 109 дүгээр тушаалаар "Ардын Армийн 109 дүгээр төв лаборатори" нэртэйгээр анх 1983 онд байгуулагджээ.

Шатахууны лаборатори нь Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад хадгалагдаж, нийлүүлэгдэж, ашиглагдаж байгаа шатахуун тос тосолгооны материал, тусгай шингэнд чанарын шинжилгээ, хяналтын хэмжилт хийж, дүгнэлт гаргаж, чанар байдлыг тодорхойлох үндсэн үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн.

Шатахуун, тос тосолгооны материал, тусгай шингэнд чанарын шинжилгээ хийж, чанар байдлыг тодорхойлох үндсэн үүргээ бүрэн биелүүлж ирсэн.

Химич инженерээр Ц.Цанжид, н.Эрдэнэцэцэг,

н.Саранцэцэг, н.Алтангэрэл нар ажиллаж байжээ. 2002 оноос хойш инженер-химичээр Ү.Эрдэнэчимэг, Ч.Хишигдалай, Ж.Алтанзул, Л.Булгантуяа, Ж.Солонго, П.Чинзориг, Ө.Ариун, Б.Ариунзаяа, Ц.Уранцэцэг, лаборантаар Ж.Мөнгөнцэцэг, Ц.Сумъяа, Я.Ганчимэг, Б.Отгонжаргал, жолооч-цахилгаанчээр ахлах ахлагч Б.Магсар, Г.Баасанбаяр, Ш.Нэргүй, Т.Отгонмөнх, Д.Энхбат, Б.Сундуйжав нар ажилла байсан.

Зэвсэгт хүчинд ашиглагдаж, хадгалагдаж байгаа шатахуун, тос тосолгооны материалын чанар стандартын шаардлагыг хангуулах ажлыг зохион байгуулж байна. Мөн лабораторийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, шатахууны лабораторийг Стандарт, Хэмжилзүйн Газар, Үндэсний итгэмжлэлийн төвөөр итгэмжлүүлэн, үйл ажиллагаагаа явуулж байна.

МАЛ ЭМНЭЛЭГ, БАКТЕРИ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН ТОВЧ ТҮҮХ



Мал эмнэлэг, бактери шинжилгээний лаборатори нь Батлан хамгаалах яамны сайдын 1972 оны тушаалаар "Хүн, мал эмнэлгийн нэгдсэн лаборатори" нэртэйгээр байгуулагджээ.

Мал эмнэлэг, бактери шинжилгээний лаборатори нь Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт нийлүүлэгдэх мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдэд сорилт шинжилгээ хийж, оператив нөөцийн болон туслах аж ахуйн мал, амьтанд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, халдварт болон

паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн.

Мал эмнэлгийн үзлэг, оношилгоо, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд ариун цэврийн магадлан шинжилгээ хийх үндсэн үүргээ бүрэн биелүүлж ирсэн.

Их эмчээр хошууч Д.Пүрвээ, ахмад Ганбат, Г.Ядмаа, н.Баярсайхан, Х.Нацагдорж, н.Эрдэнэчимэг, н.Цэцэгмаа, н.Цэндсүрэн, Н.Өлзийбулган, Ц.Баасанжав, Д.Батжаргал, Л.Баттулга, лаборантаар н.Жүгдэр, н.Цэндбаатар, н.Сэмжидмаа, Б.Жаргал, автоклавчээр Ч.Цогзолмаа, Ц.Янжинхишиг нар ажиллаж байжээ. ЗХЖШ-ын даргын тушаалаар Мал эмнэлэг, бактери шинжилгээний лаборатори нь 2007 онд Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн бүтэцэд орж үйл ажиллагаа явуулж байна.

ХИМИЙН ЛАБОРАТОРИЙН ТОВЧ ТҮҮХ

Химийн лаборатори нь Ардын цэргийн хэрэг эрхлэх яамны сайдын 1962 оны 40 дүгээр тушаалаар Ардын цэргийн Ерөнхий штабын Химийн албаны захиргаанд "Химийн лаборатори" нэртэйгээр анх байгуулагджээ.

Химийн лаборатори нь Зэвсэгт хүчний нэгтгэл анги, байгууллагуудад ашиглагдаж, хадгалагдаж байгаа цацраг идэвхит үүсгүүрүүдийн хувийн идэвхийг тодорхойлж, цацрагийн хордолтоос урьдчилан сэргийлэх, ашиглагдаж байгаа тусгай цэвэрлэгээ, ариутгалын бодис, утаат хэрэгслүүдэд химийн

лабораторийн шинжилгээ хийж, чанар байдлыг тодорхойлох үндсэн үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн.

Лабораторийн шинжилгээ хийж, чанар байдлыг тодорхойлох үндсэн үүргээ биелүүлж ирсэн.

Радиологич инженерээр ахмад Л.Гансүх, дэслэгч Б.Оюунбилэг, химич инженерээр Л.Чулуунбаатар, С.Цэрэндолгор, Л.Гансүх, Б.Оюунбилэг, Ц.Туяа, Д.Долгормаа, лаборантаар Ч.Аюурзана, Д.Оюунгэрэл, Л.Маамхүү, О.Билгээ, Л.Оюунцэцэг, нар ажиллаж байжээ.

